



# СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№32 /246/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.02.16



Монгол цэрэг энхийн үйлсэд

## ОДООГИЙН БАЙДЛААР ДАВХАРДСАН ТООГООР 20000 ГАРУЙ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЭД БАЙНА

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААН ДАХЬ ОРОЛЦОО

Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө, эрсдэл зэргийг үндэслэн НҮБ-ын бүрэн эрхт гишүүн орныхоо үүргийг гүйцэтгэн энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнийг оролцуулах, дэлхийн энх тайван аюулгүй байдалд хувь нэмрээ оруулах бодлогыг дэвшүүлсэн. Энэхүү бодлогын дагуу УИХ-аас 2002 онд "Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай", "Цэрэг, цагдаагийн алба хаагчдыг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай" хуулиудыг батлан гаргаж, тайван цагт Зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийг тодорхойлсон төдийгүй энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнийг оролцуулах,

болсон юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагаанд дахь оролцоо нь анхны цэргийн 2 ажиглагч офицерыг 2002 онд Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд илгээснээс эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар давхардсан тоогоор 20000 гаруй цэргийн алба хаагч энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгээд байгаа бөгөөд үүнээс 800 гаруй нь эмэгтэй цэргийн алба хаагч байгаа юм.

Одоогийн байдлаар НҮБ-ын 13 энхийг сахиулах ажиллагаа явагдаж байгаа бөгөөд Монгол Улсын Зэвсэгт хүчин нь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг илгээгч орнуудын жагсаалтад 2021 оны 8 дугаар сарын

Улсын Зэвсэгт хүчний цэргийн багуудыг НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгүүлэх, энхийг сахиулах ажиллагааны чадавх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Түргэн байрлах хүчний рот, Инженерийн рот, Цэргийн хээрийн хоёрдугаар шатны эмнэлгийг НҮБ-ын үнэлгээний багт танилцуулан, үнэлүүлэн ажиллаж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс үүрэг гүйцэтгэж буй мотобуудлагын батальонууд нь орон нутгийн иргэдэд чиглэсэн Иргэн-цэргийн харилцааны болон сайн үйлсийн хүмүүнлэгийн үйл ажиллагаанууд тэр дундаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл ахуйн орчин нөхцөлийг сайжруулах, сурч боловсрох нөхцөл байдлыг бүрдүүлэх, инженерийн тусалцаа дэмжлэг үзүүлэх зэрэг олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулдаг. Үүний нэг жишээ нь Абиемном суурин дахь хүн эмнэлгийн байрыг иж бүрэн засварлаж тохижуулсан сэргээн босголтын ажил, мөн Париаан суурин дахь сургуулийн барилгыг сэргээн засварлаж орон нутгийн хүүхдүүдийг сурч боловсрох нөхцөл байдлыг бүрдүүлсэн явдал юм.

### ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОНЫ АЧ ХОЛБОГДОЛ

- Монгол Улсын аюулгүй байдлыг улс төр дипломатын аргаар хангах, төрийн гадаад бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх байр суурийг бэхжүүлэх;
- Дэлхий дахинд болон бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх;
- Зэвсэгт хүчний хөгжлийн санг бүрдүүлэх;
- Цэргийн алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх.

### Дүгнэлт:

• Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид бие бялдар, сэтгэл зүйн хувьд цаг агаарын эрс тэс уур амьсгал, газар орны хүндэрсэн орчин нөхцөлд богино хугацаанд дасан зохицож, цагийн байдлын ямар ч үед өмнөө тавигдсан үүргийг цэргийн мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж буй чадварыг НҮБ, Олон улсын эвслийн Хүчний штаб, тухайн орны Зэвсэгт хүчнээс өндөрөөр үнэлж, цаашид энхийг сахиулах ажиллагааны оролцоог нэмэгдүүлэх, энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургалт дадлагуудыг хамтран зохион байгуулж, харилцан туршлага солилцохыг бодлогын түвшинд эрмэлзэх болсон байна.

• Энхийг дэмжих ажиллагаанд оролцсоноор цэргийн алба хаагчдын мэргэжлийн ур чадвар дээшлэн орчин үеийн цэргийн ажиллагаанд ашиглагдаж байгаа техник, технологид суралцахаас гадна эх орон, гэр бүл, монгол хүний эрхэмлэх үнэт зүйлийг илүү ихээр ойлгож мэдэрснээр цэргийн алба хаагчийн ёс зүй, эх оронч үзэл улам бүр батжин төлөвшиж байна.

• Түүнчлэн энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагчдын хувьд өөрийгөө хөгжүүлэн гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх, албандаа мэргэших хандлага улам нэмэгдэж, Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны чадавхийг бэхжүүлэн улс орны нэр хүндийг дэлхий дахинд өндөрт өргөн таниулж, Монгол Улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцоог бүх талаар дэмжиж, олон тулгуурт гадаад бодлогын үндсэн нөхцөлийг хангахад чухал үүрэг хүлээж байна.

### ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС



түүний гүйцэтгэх үүргийг албан ёсоор хуульчлан баталгаажуулсан.

Орчин үеийн энхийг сахиулах ажиллагааны төрөл, далайц өөрчлөгдөж, энхийг сахиулагчдын гүйцэтгэх үүрэг нэмэгдэж, цэргийн алба хаагчдын аюулгүй байдал, нийгмийн хамгаалалтай холбоотой асуудлыг оновчтой шийдвэрлэх, Монгол Улсын НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд дахь оролцоо өргөжсөнтэй холбоотойгоор УИХ-аас 2010 онд "Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай" хуулийг шинэчлэн баталсан билээ. Ингэснээр НҮБ-ын гишүүн орны хувьд үүргээ биелүүлж дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад хувь нэмрээ оруулах, олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох эрх зүйн орчин улам боловсронгуй

31-ний өдрийн байдлаар 24 дүгээрт бичигдэж байгаа нь Монгол Улсын хүн ам, Зэвсэгт хүчний боломж, хүний нөөцийн чадавхтай харьцуулахад чамлахааргүй амжилт, хүчин чармайлт, хувь нэмэр юм.

"Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичгийн 8.2.8, "Зэвсэгт хүчний тухай" хуулийн 6.2.4, "Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай" хууль, "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийн 3.2.4 дэх заалт болон Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030" баримт бичгийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд батлан хамгаалах чиглэлээр тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН
2,270,545 /69.8%/	2,171,826 /66.8%/	1,015,670 31,0%
		92,216 /2,8%/

## ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
8157 +112	109	7931

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 416,057,035
Эдгэрсэн
Нийт: 338,806,009
Нас барсан
Нийт: 5,857,018

## Түүхэнд энэ өдөр

1912 он  
Улиастайд сууж байсан манжийн амбан, сайд, түшмэдийг хөөн явуулав.

1913 он.  
Монгол цэргийн бригад байгуулах тухай Монгол, Оросын хэлэлцээрт Нийслэл Хүрээнд гарын үсэг зурав.

2004 он.  
"Иракийн эрх чөлөө" ажиллагаанд оролцсон Цэргийн багийг угтан авах ажиллагааг зохион байгуулав.

## ЦАГ АГААР

### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-10	-29


### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
40	23

## ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,861.00	2,864.0
EUR	3,240.0	3,255.0
CNY	450.00	451.00
RUB	37.40	38.20
JPY	24.73	24.85
KRW	2.40	2.41

## ЗУРХАЙ



2022.02.16 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 15/

ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААН ХУЛГАНА ӨДӨР

### Үс засуулбал:

Өлзийтэй сайн  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
07.54-18.15  
БАРИЛДЛАГА:  
Үхэх  
Шүтэн барилдлага:  
Хүрэлцэхүй  
Суудал: Ус

Энэ өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, хараал, жатхыг буцаах, нялхсын хурим хийх, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар ухах, худаг гаргах, уул овоо тахихад муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, мал арвидна.



Цахим шууданд

# “MILITARY BAND” ХАМТЛАГИЙН ЗАЛУУС “АМИН ТАНГАРАГТАЙ ЭХ ОРОН”-ОО МАГТАН ДУУЛЖ ЯВНА



ЦДБЭЧ-ын түүхт 90 жилийн ой энэ онд тохиож байгаа билээ. Яруу алдар, омогшил дуурьслаа өргөсөн он цагийн түүхийг оршоож цэргийн чуулгын дэргэдэх “MILITARY BAND” хамтлагийн залуус Улаанбаатар цэргийн хүрээний анги, байгууллагуудын цэрэг дайчдадаа “Амин

тангарагтай эх орон” талархлын тоглолтоо өргөн барьсаар байна. З Х Ж Ш - ы н даргын болон ЦДБЭЧ-ын даргын тушаалаар зохион байгуулагдан цэрэг эрсийнхээ жавхаа хийморийг бахдан дуулж буй тус тоглолтын үзэгчид талархлын сэтгэгдлээ илэрхийлж, амжилт, уран

бүтээлийн гэгээн хийморийн дээдийг “MILITARY BAND” хамтлагийн залуустаа болон яруу түүхт ЦДБЭЧ-ын хамт олонд ирүүлсээр байна. Цэргийн чуулгаар овоглож, омогшсон хүмүүн бүхэнд Монгол цэргийн уянга хөглөх энэхүү тоглолт ирэх сарын 2-ны өдрийг хүртэл зохион байгуулагдахаар төлөвлөгджээ.



## ТҮМЭНДЭЭ ТАЛАРХСАН “МЯЛААЛГА” ТОГЛОЛТ ТУН УДАХГҮЙ ...



түмний уянгын их эгшиглэнг өргөж талархсан сэтгэлээ дуугаараа мялаахаар заллага хүргэж байна.

УГЗ Б.Магсаржавын алдарт дуунууд эгшиглэх энэхүү тоглолтод ЦДБЭЧ-ын уран бүтээлчид бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцохоор бэлтгэл ажлаа хангаж байна.

Өдгөө ч алдарт цэргийн чуулгадаа ажиллаж, яруу бүтээлүүдээ туурвисаар байгаа УГЗ Б.Магсаржавын “Мялаалга” уран бүтээлийн тоглолт нь ЦДБЭЧ-ын түүхт 90 жилийн ойг угтан, ахмад уран бүтээлчдээ дэмжин ажиллаж байгаа өрнүүн ажлын эхлэл юм.

“Зүүдэн бороо”, “Ээжийн чанасан цай”, “Хуурангийн шөнө”, “Хар нүдэн бүсгүй”, “Насны намар”, “Сүслэн хайрлаж яваарай”, “Зүрхний уяа” зэрэг эгшиглэнд өлгийдсөн яруу дуугаараа ард түмнийхээ сэтгэлийг хөглөгч МУУГЗ Б.Магсаржавын “Мялаалга” уран бүтээлийн тоглолт энэ сарын 18-нд “УБ палас”-ын их тайзнаас үзэгчдийн хүртээл болох юм. Уран бүтээлийн их замаа ЦДБЭЧ-тай холбож, бүжгийн концертмейстерээр ажлын гараагаа эхэлж байсан тэрээр өдгөө Монголын ард



Гадаад мэдээ

## ОХУ ОЙРЫН ӨДРҮҮДЭД УКРАИНД ХАЛДАЖ МАГАДГҮЙ

“ОХУ ойрын өдрүүдэд Украинд халдаж магадгүй” гэсэн АНУ-ын анхааруулгыг ОХУ-ын Ерөнхийлөгч үгүйсгэлээ. ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Гадаад хэргийн болон Батлан хамгаалахын сайд нартайгаа хийсэн уулзалтын үеэр “Аюулгүй байдлын асуудлыг

шийдэхийн тулд дипломат шийдэл хайх”-аа онцолсон байна. Владимир Путин энэхүү мэдэгдлийн дараа Батлан хамгаалахын сайд нь “ОХУ-ын цэргийн сургуулиалтууд ихэнх нь дууссан”-ыг мэдээлжээ. Хэдий тийм боловч цэргүүдийг эргүүлэн татах эсэх талаар тодорхой мэдээлэл өгөөгүй байна.

Үүний зэрэгцээ ХБНГУ-ын Канцлер Олаф Шольц “NATO одоогоор Украиныг гишүүнээр элсүүлэхээр зориогүй байна” гэж мэдэгдлээ. Үүний хариуд Украины Ерөнхийлөгч Владимир Зеленский “NATO-д элсэх эсэх нь Украины иргэдийн шийдвэр байх болно” гэсэн байна.

